



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/181

Бат-Өлзий сум

Захирамжийн зарим хэсэгт өөрчлөлт
оруулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, Засгийн газрын “Геодезийн солбилцол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоог батлах тухай” 2009 оны 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ийн XXI.1.43-д тусгагдсан “Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах геодезийн солбилцол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажил хэрэгжсэнтэй холбогдуулан Засаг даргын Тамгын газрын эзэмшсэн газрын хэмжээ өөрчлөгдсөнийг хавсралтаар баталсугай.

2. Захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2008 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 56 дугаар захирамжийн холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.

3. Газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, улсын бүртгэлд бүртгэх, газрыг зориулалтын дагуу эзэмшиж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (И.Маралмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

Сумын Засаг даргын Оны... дугаар сарын-ны
 өдрийн... дугаар захирамжийн хавсралт

ЭЗЭМШСЭН ГАЗРЫН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨГДСӨН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Өмчлөгчийн		Хамтран өмчлөгчийн					Өмнөх захирамжийн		
	Аж ахуйн нэгж байгууллагын нэр	Регистр	Эцэг /эх-ийн нэр	Нэр	Регистр	Огноо	Дугаар	Хавсралтын дугаар	Холбогдох хэсгийн дугаар	
0	1	2	3	4	5	6	7	8	9	
1	Засаг даргын Тамгын газар	9045651				2008.06.18	56	1	1	

Д/д	Өмнөх Газрын		Газрын			Хугацаа
	Нэгж талбарын дугаар	Хэмжээ /м2/	Нэгж талбарын дугаар	Хэмжээ /м2/	Байршил	
0	10	11	12	13	14	17
1	6221000332	1098	6221000332	1455	5-р баг Төв 4-403	1746000
					Тэжээл, бордооны агуулах	1

--000000--